

01. Ээлжит хичээлийн бүртгэл

Аль бүлэгт, хэн багш, ямар хичээлийг, аль танхимд, ямар хуваариар хичээллэхийг бүртгэснийг "**Ээлжит хичээлийн бүртгэл**" гэж БСМС -д ойлгоно.

Хуваарь* гэдэг нь: Тухайн хичээлийг аль улиралд, хэддүгээр ээлжинд, долоо хоногт хэдэн удаа, ямар гарагт, хэддүгээр цагт хичээллэх бүртгэл юм.

Ээлжит хичээлийн бүртгэл нь **Үндсэн бүртгэл** болон **Хуваарийн бүртгэл** гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Ээлжит хичээлийн бүртгэлийг **Анги удирдсан багш** эсвэл **Сургалтын менежер** бүртгэнэ.

Хэрэв Анги удирдсан багш ээлжит хичээлийн бүртгэл хийсэн бол Сургалтын менежер **Баталгаажуулалт** хийх шаардлагатай.

Сургалтын менежер **Ээлжит хичээлүүдийг** баталгаажуулсанаар хичээл заадаг багш **Цахим журнал хөтлөх** боломжтой болно.

Ээлжит хичээл үүсгэх төрөл:

Үндсэн бүлэг: Анги нийтээрээ орох хичээлийг тухайн төрлийг сонгож ээлжит хичээл үүсгэнэ.

Жишээ нь: Монгол хэл 7 /заавал хичээл/ бүх суралцагч судлах ёстой.

Дэд бүлэг: Нэг бүлгийн суралцагчдийг дэд бүлэг болгон хувааж ордог хичээлийн тухайн төрлийг сонгож ээлжит хичээл үүсгэнэ.

Жишээ нь: Технологийн хичээлийг эрэгтэй, эмэгтэй суралцагчаар хуваагдаж ордог бол Технологи 7-а /эр/, Технологи 7-а /эм/ үүсгэнэ.

Хичээлийн бүлэг: Олон бүлэгт нэг болон олон хичээлийг нэг хуваариар хичээллэж буй бол тухайн төрлийг сургалтын менежер ээлжит хичээлийг үүсгэнэ.

Ээлжит хичээл хэрхэн үүсгэх:

Анги удирдсан багш системд эрхээр нэвтэрч орж хариуцсан ангид ордог ээлжит хичээл болон тухайн хичээлийн хуваарийг оруулна.

Ээлжит хичээлийн бүртгэл шинээр үүсгэх бол дэлгэцний баруун дээд байрлах **ҮЙЛДЭЛ - Ээлжит хичээл нэмэх** товчийг сонгоно.

ҮЙЛДЭЛ:

- 1. Хичээл заадаг багш тохируулах** - Анги удирдсан багш өөрийн даасан ангид ордог хичээлүүдийн заадаг багшийг тохируулж өгнө.
- 2. Жагсаалтаар хичээл нэмэх** - Төлөвлөгөөнд тусгасан заавал ордог хичээлүүдийг бөөнөөр үүсгэх
- 3. Ээлжит хичээл нэмэх** - Ээлжит хичээлүүдийг нэг нэгээр үүсгэх

Зураг 2: Ээлжит хичээл үүсгэх

1. Хичээл заадаг багш тохируулах

Зураг 3: Хичээл заадаг багш тохируулах

Анхаарах:

Нэмэх товчийг сонгож тухайн хичээлийг заадаг багшийн нэрийг оруулж өгнө.

Хэрэв та тухайн хичээлийг заадаг багшийн мэдээллийг цуцлах бол багшийн нэр дээр дарахад алга болно.

2. Жагсаалтаар хичээл нэмэх

Зураг 4: Жагсаалтаар заавал хичээл үүсгэх

Анхаарах:

Анги, хонхны дуугарах хуваарийг сонгосны дараа ногоон өнгийн **нэмэх** товчийг дарж тухайн хичээлийг үүсгэнэ.

Хичээлийн төрөл сонгох - Үндсэн болон дэд бүлгээр хичээллэх

Долоо хоногт орох цагийн тоог улиралд харгалзан оруулна. Жишээ нь: Биеийн тамир 1-р улиралд 7 хоногт 1 цагаар орно.

Тухайн хичээлийг заах багш болон хичээллэх танхимыг сонгоно. Үүний дараа бусад хичээлүүдийг үүний нэгэн адил оруулж хадгалах товч дарна. Дахин ээлжит хичээлийн нэрийг сонгож **Хичээлийн хуваарийг** /Хэд дэх өдөр хэддүгээр цагт орох/ оруулан хадгална. **Төлөв** нь батлагдаагүй төлөвт байх ба үүнийг сургалтын менежер **баталгаажуулна**.

3. Ээлжит хичээл нэмэх

Хичээлийн төрлөө сонгосны дараа **Хонх дуугарах хуваарь** хэсэгт Бага ангийн эсвэл Ахлах, дунд ангийн цагийн хуваариа сонгоно.

Үүний дараа **Хичээл** талбарт ээлжит хичээл үүсгэх хичээлээ сонгоно.

Тухайн ээлжит хичээл нь хэддүгээр улиралд орох тохиргоог хийхдээ **Улирал** хэсэгт хийнэ. Хэрвээ тус ээлжит хичээл нь 4-р улиралд ордоггүй бол 4-р улирлын өмнөх сонголтыг арилгана

Анхаарах нь: Хэрвээ улирлын сонголт сонгоогүй ээлжит хичээлийг баталгаажуулсан бол сургалтын менежерийн эрхээс тухайн ээлжит хичээлийн улирлыг сонгож оруулдаг. Иймээс анх ээлжит хичээл үүсгэхдээ тухайн ээлжит хичээл 4 улирал ордог бол өөрчлөлт хийхгүй баталгаажуулна уу.

Хичээл талбарт ээлжит хичээл үүсгэх хичээл сонгосноор **БҮЛЭГ** талбарт тухайн ээлжит хичээлийн нэр, товч нэр автоматаар үүснэ. Та гараас өөрчлөх боломжтой. /Дэд бүлгээр үүсгэсэн хичээлийн хувьд **ТОВЧ НЭРҮҮДИЙГ** нь ялгавартай байхаар засах/

Энэ хэсэгт тус ээлжит хичээлийг заах Багш болон хичээл орох танхимыг сонгож өгнө.

Ээлжит хичээл шинээр үүсгэх цонхны бүх талбаруудыг бөглөн, **Хадгалах** товч дарснаар ээлжит хичээл шинээр үүсгэнэ.

Шинээр үүсгэсэн ээлжит хичээл нь **батлагдаагүй** төлөвтэй байх бөгөөд зөвхөн сургалтын менежер тухайн ээлжит хичээлүүдийг баталгаажуулна.

Уг батлагдсан ээлжит хичээлд хичээлийн хуваарийг "Хуваарь засварлах" үйлдлээр бүртгэнэ.

Дараах линкээр орж хичээлийн хуваарийг хэрхэн бүртгэх заавар авна уу.